



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2021 оны 9 сарын 13 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

**Хуралдааныг цахимаар
зохион байгуулах тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 259 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Цахим хуралдааны бэлтгэлийг хангаж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000222